



**ХАН-УУЛ ДҮҮРГИЙН  
ОНЦГОЙ КОМИСС**

17042 Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 3 дугаар хороо,  
Чингисийн өргөн чөлөө, Иргэдэд үйлчлэх төв байр  
Утас: 7019-2584, 7019-2583  
E-mail: obh.han-uul@yahoo.com  
<http://www.nobg.ub.gov.mn/>

2020.02.21 № 03

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Г ХАН-УУЛ ДҮҮРГИЙН ЗАСАГ  
ДАРГЫН ДЭРГЭДЭХ ХЭЛТЭС,  
АЛБАДЫ ДАРГА, ХОРООДЫН  
ЗАСАГ ДАРГА НАРТ

Монгол Улсын Засгийн газрын “Бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг сунгах тухай” 64 дүгээр тогтоол, хуралдааны тэмдэглэл, Улсын Онцгой комиссын 05 дугаар хурлын тэмдэглэлийг тус тус хүргүүлэв.

Хэрэгжилтийг ханган ажиллана уу.

Хавсралт 7 хуудастай.

ОРЛОГЧ ДАРГА,  
ДЭД ХУРАНДАА



В.БАТСАЙХАН

УЖ30004



# МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2020 оны 2 дугаар  
сарын 19-ний өдөр

Дугаар 64

Улаанбаатар  
хот

Бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн  
хугацааг сунгах тухай

Монгол Улсын хилийн тухай хуулийн 21.2, 28.2, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 11.3.3-т заасныг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. БНХАУ-д гарсан шинэ коронавирусийн халдвар (COVID-19)-ын тархалт буурахгүй байгаатай холбогдуулан халдвараас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах зорилгоор улсын хэмжээнд засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээдийг гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт хэсэгчилсэн байдлаар шилжүүлсэн хугацааг 2020 оны 3 дугаар сарын 30-ны өдрийг хүртэл сунгасугай.

2. Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг сунгасантай холбогдуулан энэ тогтоолын 1-д заасан хугацаанд дараахь арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд Ё.Баатарбилэгт даалгасугай:

2.1. цэцэрлэг, сургуулийн үйл ажиллагааг түр зогсоох хугацаанд хүүхдийн хоол, үдийн цайны зардлаас хэмнэгдсэн хөрөнгийг бямба гарагт хичээллэх багш, ажилтны цалин хөлс болон тухайн байгууллагад ариутгал, халдваргүйтгэлийн материал худалдан авахад зарцуулах;

2.2. ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад зориулсан теле хичээлийг үргэлжлүүлэх, багш нарын 1, 5, 10 дахь жилийн мэргэжил дээшлүүлэх сургалтыг онлайн хэлбэрээр зохион байгуулахад шаардагдах зардлыг батлагдсан төсөвтөө зохицуулалт хийж шийдвэрлэх.

3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Шинэ коронавирусийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2020 оны 30 дугаар тогтоолын 5 дахь заалт, “Хилийн боомтыг түр хаах, нэвтрэх хөдөлгөөнийг хязгаарлах тухай” Засгийн газрын 2020 оны 39 дүгээр тогтоолын 1.1 дэх дэд заалт, “Бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх тухай” Засгийн газрын 2020 оны 62 дугаар тогтоолын 1 дэх заалт, “Бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2020 оны 63 дугаар тогтоолын 1 дэх заалтын “3 дугаар сарын 2-ны” гэснийг “3 дугаар сарын 30-ны” гэж тус тус өөрчилсүгэй.

4. Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Шинэ коронавирусийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2020 оны 30 дугаар тогтоолын 5 дахь заалтын “3,” гэснийг, “Хилийн боомтыг түр хаах, нэвтрэх хөдөлгөөнийг хязгаарлах тухай” Засгийн газрын 2020 оны 39 дүгээр тогтоолын 3 дахь заалтын “албан ажлын” гэснийг тус тус хассугай.



Монгол Улсын Ерөнхий сайд

Батлан хамгаалахын сайд

У.ХҮРЭЛСҮХ

Н.ЭНХБОЛД



# МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС

## ШАДАР САЙДЫН АЖЛЫН АЛБАНД

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 2 дугаар сарын 19-ний өдрийн хуралдааны 11 дүгээр тэмдэглэлд:

"1.ХЭЛЭЛЦСЭН нь: Бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг сунгах тухай

ШИЙДВЭРЛЭСЭН нь: 1. Бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг сунгах тухай асуудлыг хэлэлцээд тогтоол гаргахаар тогтов.

2. Монгол, хятадын хилийн авто замын боомтуудаар нүүрс, газрын тос тээвэрлэлтийг сэргээх, улс хоорондын ачаа тээврийн галт тэрэг, авто машин болон төмөр замын ажилтан, зүтгүүрийн бие бүрэлдэхүүн, жолооч нарт ариутгал, халдваргүйтгэлийн дэглэмийг чанд сахиулах, жолооч нарын нутгийн гүн рүү зорчих, тээвэрлэлт хийх хөдөлгөөнд онцгойлон анхаарч, нэгдсэн хяналт тавих асуудлаар холбогдох шийдвэр гарган хэрэгжүүлэхийг Монгол Улсын Шадар сайд, Улсын онцгой комиссын дарга Ө.Энхтүвшинд даалгав." гэжээ.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР



## УЛСЫН ОНЦГОЙ КОМИССЫН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2020 оны 2 сарын 20 өдөр

Дугаар 05

Улаанбаатар хот

### V ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

Улсын онцгой комиссын V хурал 2020 оны 2 дугаар сарын 20-ны өдрийн 12.00 цагт Төрийн ордон дахь Шадар сайдын ажлын өрөөнд 100 хувийн ирцтэй хуралдав.

Хурлыг Монгол Улсын Шадар сайд, Улсын онцгой комиссын дарга Ө.Энхтүвшин даргалж, холбогдох үүрэг, даалгаврыг өгөв.

#### ХЭЛЭЛЦСЭН НЬ:

1. Шинэ коронавируст халдвараас урьдчилан сэргийлэх, бэлтгэл, бэлэн байдлыг хангуулах чиглэлээр Улсын онцгой комиссоос авч хэрэгжүүлж буй арга хэмжээний талаар Улсын онцгой комиссын нарийн бичгийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч, Онцгой байдлын ерөнхий газрын тэргүүн дэд дарга, бригадын генерал Г.Ариунбуян;

2. Цагаан сарын баяртай холбогдуулан хот хоорондын зорчигч тээврийн хөдөлгөөнийг хязгаарлах эсэх, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар Зам, тээврийн хөгжлийн сайд Б.Энх-Амгалан, Цагдаагийн ерөнхий газрын Нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах албаны дарга, цагдаагийн хурандаа Ж.Амгалан нарын мэдээллийг сонсов.

#### ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Нэг. Зам, тээврийн хөгжлийн сайд,

Улсын онцгой комиссын гишүүн Б.Энх-Амгалан,

1.1. Улс, хот хоорондын зорчигч тээвэр, суудлын галт тэрэг болон хувийн тээврийн хэрэгслийн зорчих хөдөлгөөнийг 2020 оны 2 дугаар сарын 23-ны өдрийн 08:00 цагаас 27-ны өдрийн 08:00 цаг хүртэл түр зогсоох арга хэмжээ авах;

1.2. Улс, хот хооронд зорчигч тээвэр болон суудлын галт тэргээр зорчихоор тасалбар авсан иргэд, зорчигчдын тасалбарын үнийг шимтгэлгүйгээр буцаан олгох;

Хоёр. Эрүүл мэндийн сайд,

Улсын онцгой комиссын гишүүн Д.Сарангэрэлд:

2.1. Үүссэн нөхцөл байдалтай холбогдуулан үүрэг гүйцэтгэж байгаа ажилтан, алба хаагчдад чиглэсэн сургалтыг тогтмол зохион байгуулах;

2.2. Ариутгал, халдваргүйтгэлийн бодисыг хэрэглэх зааварчилгаа боловсруулж, холбогдох байгууллагуудад хүргүүлэх;

Гурав. Сангийн сайд Ч.Хүрэлбаатар,

Эрүүл мэндийн сайд,

Улсын онцгой комиссын гишүүн Д.Сарангэрэл нарт:

3.1. Эмч, эмнэлгийн ажилтнуудын илүү цагаар ажилласны хөлс, урамшууллыг тооцож олгох;

3.2. Дэлхийн эрүүл мэндийн байгууллага, Азийн хөгжлийн банк, Дэлхийн банкны шугамаар хэрэгжих үндэсний оношилгоо эмчилгээний "МОН-8" төслийн хүрээнд нийлүүлэгдэх эм, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмж худалдан авах үйл ажиллагааг шуурхай зохион байгуулах;

Дөрөв. Гадаад харилцааны сайд Д.Цогтбаатар

Зам, тээврийн хөгжлийн сайд,

Улсын онцгой комиссын гишүүн Б.Энх-Амгалан,

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд,

Улсын онцгой комиссын гишүүн Д.Сумьяабазар,

4.1. Монгол, Хятадын хилийн авто замын боомтуудаар нүүрс, газрын тосны тээвэрлэлтийг сэргээн, хэвийн явуулах талаар БНХАУ-ын талтай зөвшилцөн, шаардлагатай арга хэмжээг шуурхай авч ажиллах;

Тав. Зам, тээврийн хөгжлийн сайд,

Улсын онцгой комиссын гишүүн Б.Энх-Амгалан,

Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга,

Улсын онцгой комиссын гишүүн Н.Цагаанхүү

5.1. Монгол, Хятадын хилийн авто замын боомтуудаар нүүрс, газрын тосны тээвэрлэлтийг нэгдсэн удирдлага зохицуулалттайгаар зохион байгуулах, улс хоорондын ачаа тээврийн галт тэрэг, автомашин болон төмөр замын ажилтан, зүтгүүрийн бие бүрэлдэхүүн, жолооч нарын эрүүл мэнд, ариутгал халдваргүйтгэлийн дэглэм, хөдөлмөрийн аюулгүй байдлыг чанд сахиулах;



Зургаа. Нүүрс, газрын тос тээвэрлэлт эрхэлдэг аж, ахуйн нэгж,

байгууллагын захирал нарт:

6.1. Монгол, Хятадын хилийн авто замын боомтуудаар нүүрс, газрын тосны тээвэрлэлтийг сэргээн, хэвийн явуулах үйл ажиллагааны хүрээнд холбогдох яам, төрийн байгууллагаас авч хэрэгжүүлж буй арга хэмжээг хэрэгжүүлэх, мэргэжлийн байгууллагын зөвлөмж, зөвлөгөөг дагаж мөрдөх;

6.2. Вирусийн халдварын сэжигтэй тохиолдол илэрсэн үед тусгаарлах байр, ариутгалын пунктыг бэлтгэж, тээврийн хэрэгслийн жолооч нарын хоол хүнс, дархлаажуулалт, ариутгал халдваргүйтгэлийн бодис, амны хаалт, хамгаалах хувцас хэрэглэлээр хангах ажлыг зохион байгуулах;

Долоо. Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга,

Улсын онцгой комиссын гишүүн Н.Цагаанхүүд

7.1. Шинэ коронавируст халдварын үед ажиллах орон нутгийн шалган нэвтрүүлэх хяналтын цэгт ариутгал, халдваргүйтгэл хийх түр журам боловсруулан батлуулж, холбогдох байгууллагад хүргүүлж, мөрдүүлж ажиллах;

7.2. "Талх чихэр" ХК, "Саруул-Оч" ХХК-ийн БНХАУ-ын Хубэй мужаас импортоор оруулж ирсэн гүнждийн үр, дрожи, давсыг шинжилгээний болон ариутгал халдваргүйтгэлийн дүгнэлтийг үндэслэн гаалийн хяналтын талбайгаас чөлөөлж, ачаа хүлээн авагчид олгох;

Найм. Байгаль орчин, аялал жуулчлалын сайд,

Улсын онцгой комиссын гишүүн Н.Цэрэнбат

Зам, тээврийн хөгжлийн сайд,

Улсын онцгой комиссын гишүүн Б.Энх-Амгалан нарт:

8.1. Шинэ коронавируст халдвар бүртгэгдсэн улс орон руу аялал, жуулчлалын үйл ажиллагааг зохион байгуулахгүй байх талаар аялал жуулчлалын компаниудад чиглэл өгөх, хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлах ;

Ес. Аймаг, нийслэлийн Засаг дарга,

Онцгой комиссын дарга нарт:

9.1 Тээврийн хэрэгслийн зорчих хөдөлгөөнийг түр зогсоосонтой холбогдуулан, хот хоорондын авто тээврийн шалган нэвтрүүлэх товчоо, хяналтын цэгүүдэд ажиллах бүрэлдэхүүнийг томилж, нэгдсэн удирдлага зохицуулалтаар хангах;

9.2. Хүндэтгэн үзэх шалтгааны улмаас (ар гэрийн гачигдал, эмнэлгийн яаралтай тусламж, үйлчилгээ, албан томилолт, ажлын зайлшгүй шаардлага гэх мэт) улс, хот хооронд зорчих төрийн албан хаагч болон иргэдийн нотлох баримтыг үндэслэн хүндрэл, чирэгдэл учруулахгүйгээр нэвтрүүлэх арга хэмжээг тухай бүр авч ажиллах;


9.3 Иргэдийн хүнсний хангамжийн тогтвортой байдал, эрүүл ахуй, ариун цэврийн хэвийн үйл ажиллагааг дэмжих зорилгоор хүнсний зах, худалдааны төв, дэлгүүр, халуун усны газар, усан спортын төв, спорт заал (их, дээд болон, мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төв, коллеж, ерөнхий боловсролын сургуулийн заалнаас бусад) бялдаржуулах төвийн үйл ажиллагааг хязгаарлахгүй байх, ариутгал, халдваргүйтгэлийг стандартын дагуу тогтмол хийлгүүлэх, хяналт тавьж ажиллах;


9.4. Эм, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмж, хамгаалах хувцас хэрэгсэл, ариутгал, халдваргүйтгэлийн бодис, амны хаалтны нөөцийг бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлэх;

9.5. Шадар сайдын 2017 оны А/08 дугаар тушаалаар батлагдсан эрсдэлийн үнэлгээний аргачлалын дагуу аймаг нийслэлийн түвшинд шинэ коронавируст халдварын эрсдэлийг үнэлэх, салбар тус бүр халдварын дэгдэлт үүссэн тохиолдолд даван туулах чадавхийн үнэлгээг 2020 оны 3 дугаар сарын 10-ны өдрийн дотор хийж гүйцэтгэх;

9.6. Тусгаарлах шаардлагатай иргэдийг түр байрлуулах, хсооллох, коронавируст халдварын сэжигтэй тохиолдол, хавьтлыг илрүүлэх тандалт судалгаа хийхэд эрүүл мэндийн байгууллагад дэмжлэг үзүүлж ажиллах;

9.7. Шашин, сүм хийдийн хурал, цуглаан, зан үйлд иргэд, олон нийтийг оролцуулахгүй байх, уул, овоо тахих, галын тахилга, ёслол үйлдэх, шинийн нэгний нар харах зэрэг арга хэмжээг зохион байгуулахгүй байхыг тус тус үүрэг болгож байна.

МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙД,  
УЛСЫН ОНЦГОЙ КОМИССЫН ДАРГА  Ө.ЭНХТҮВШИН

УЛСЫН ОНЦГОЙ КОМИССЫН НАРИЙН  
БИЧГИЙН ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН  
ГҮЙЦЭТГЭГЧ, ОНЦГОЙ БАЙДЛЫН  
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ТЭРГҮҮН ДЭД ДАРГА,  
БРИГАДЫН ГЕНЕРАЛ  Г.АРИУНБУЯН

